

11 ДҮГЭЭР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

ХУГАЦАА-60 минут

Санамж: Өгөгдсөн даалгаврын зааврыг анхааралтай уншиж зөв хариултаа дугуйлаарай.

1-р хэсэг: Сонгох даалгавар зөвхөн нэг зөв хариултыг сонгоно.

2-р хэсэг: Харгалзуулах даалгавар тус бүр 1 оноотой.

“А” ВАРИАНТ

Нэгдүгээр хэсэг

1. К.Марксын үзсэнээр капиталистууд ажилчин ангийг хэрхэн мөлждөг вэ?
 - A. Өөрийн ажилчдад цалин өгөлгүйгээр
 - B. Нэмүү өртгийг ажилчдаар бүтээлгэн, өөрсдөө авч
 - C. Ажилчдыг шалтгаангүйгээр ажиллуулан
 - D. Ашгийг ажилчдад хуваарилж
2. Язгуурын давхраажилтын хэв маяг дараах нийгмүүдийн алинд нь зонхилдог вэ?
 - A. Орчин үеийн нийгэм
 - B. Газар тариалангийн нийгэм
 - C. Аж үйлдвэржсэн нийгэм
 - D. Мэдээллийн нийгэм
 - E. Ан агнуурын нийгэм
3. Тодорхой цаг хугацааны хүрээнд нийгмийн бүтэц, соёл, нийгмийн институт, хүмүүсийн зан үйл шинэчлэгдэхийг гэнэ.
 - A. Нийгмийн өөрчлөлт
 - B. Нийгмийн шинэчлэл
 - C. Нийгмийн хувьсгал
 - D. Нийгмийн харилцаа
4. Өнөө цагт нийгмийг уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх, орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм, орчин үеийн дараах буюу аж үйлдвэржилтийн дараах нийгэм гэсэн хэв маягт хуваасан социологич хэн бэ?
 - A. К.Маркс
 - B. Г.Ленский, Ж.Ленский
 - C. Ф. Тённис
 - D. Т.Билтон
5. Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдол аль нь бэ?
 - A. Дэлхий нийтэд өөрсдийн брэндийг бий болгоно эдийн засгийн эрэлт огцом өснө
 - B. Эдийн засгийн эрэлт огцом өснө
 - C. Иргэдийн үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэх оролцоо өснө
 - D. Ажлын байр нэмэгдүүлдэг
 - E. А болон D зөв
6. Соёлын үйлдвэрлэл гэдэг ойлголт хэдий үед бий болсон бэ?
 - A. 1970-аад оны үед
 - B. 1980-аад оны үед
 - C. 1990-ээд оны үед
 - D. 1960-аад оны үед
7. Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг гэнэ.
 - A. Соёлын аялал жүүлчлал
 - B. Соёлын үйлдвэрлэл
 - C. Соёлын даяаршил

D. соёлын харилцан үйлчлэл

8. Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан өмнөх соёлын дадал хэвшлээсээ хавьгүй илүүд үзэж хүлээн зөвшөөрсөн сэтгэлгээний үр дүн юм. Энэ нь соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрүүдээс аль нь вэ?
A. Соёлын солилцоо В. Соёлын хуулбарлан дуурайх
C. Соёлын харилцан үйлчлэл D. Соёлын тулгалт
9. Засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны гол суурь харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай хууль бол юм
A. Эрүүгийн хууль В.үндсэн хууль C. Иргэний хууль D. Үндсэн хуулийн цэц
10. нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэй эргүүлэн төлөхийн баталгаа болох үнэт цаас юм.
A. Хувьцаа В. Банкют C. Бонд D. Депозит
11. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн , үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг..... гэнэ.
A. Цэвэр экспорт В. Үндэсний нийт бүтээгдэхүүн C. Дотоодын нийт бүтээгдэхүүн
D. дотоодын хөрөнгө оруулалт
12. нь хуулийн дагуу тогтоогдсон хэмжээгээр бүх хүн , хуулийн этгээдээс төрд заавал төлөх,буцалтгүй шинжтэй хураамж юм.
A. Татвар b. Бонд c. Төсвийн бодлого d. Төсөв
13. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгйн уналтаас өөрийгөө аварч чадахгүй гэдгийг баталж, төрийн оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх ёстой гэж үзсэн эрдэмтэн аль нь вэ
A. Ф.Хайек b. М.Кейнс c. К. Маркс d. Монтескье
14. Улс орнуудын хооронд бараа үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг гэнэ.
A. Экспорт b. Импорт c. Олон улсын худалдаа D.Худалдааны тэнцэл
15. Үндсэн хуулийн цэцийг өөрөөр юу гэж нэрлэдэг вэ?
A. Үндсэн хуулийг хамгаалагч В. Үндсэн төвт хуулийн байгууллага
C. Дээд шүүхийн сахиур D. Үндсэн хууль эзэмшигч E. Хууль эршээгч
16. Хүний эрхийг хамгаалах үндсэн үүрэгтэй субъект аль вэ?
A. Иргэний нийгмийн байгууллага В. Хувь хүн C. Төр D. Засгийн газар
E. Ерөнхийлөгч
17. Үндсэн хуулийн биелэлтэнд аль нь хяналт тавих вэ
A. УИХ b. Засгийн газар c. Цэц d. Ерөнхий прокурор
18. Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд худалдах, бэлэглэх, зээлэх, арилжих аль ч тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн авснаар өмчлөх эрх
A. Гэрчилгээ b. Баталгаа c. Дугаар d. Шимтгэл
19. гэж хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай, гэм буруутай үйлдэл , эс үйлдлийг хэлнэ .
A. Эрх зүйн зөрчил b. Гэмт хэрэг c. Гэмт хэргийн бус зөрчил d. Гэм хор
20. Иргэний нийгэм гэдэг ойлголт хэзээ бие даасан ойлголт болсон бэ?
A. XX зууны сүүл В. XVIII зууны сүүл C. XX зууны эхэн D. А болон В зөв
21. засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай засаг төрийн гол хууль юм.
A. Захиргааны тухай хууль В. Үндсэн хууль
C. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль D. Зөрчлийн тухай хууль

22. Хууль батлах эрхтэй төрийн байгууллага аль нь вэ
 А. Засгийн газар В. Улсын их хурал С. Дээд шүүх D. Тагнуулын ерөнхий газар
23. нь төрийн байгууллагынүйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан хүсэлт
 А. Гомдол В. Санал С. Мэдэгдэл D. Өргөдөл
24. Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй гэж үндсэн хуулийн хэддүгээр зүйлд заасан бэ?
 А. Үндсэн хуулийн 16-р В. Үндсэн хуулийн 17-р
 С. Үндсэн хуулийн 18-р D. Үндсэн хуулийн 19-р
25. Ажилтан ажил олгогчийн хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь ямар тохиолдолд хүчин төгөлдөр болох вэ?
 А. Ажилтан ажил олгогч харилцан тохиролцсоноор
 В. Хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр
 С.Талууд гарын үсэг зурсанаар D. Хөдөлмөрийн гэрээг хугацаатай байгуулсанаар
26. ОУБ, ОУТББ хоёрын ялгааг дурдахдаа хамааралгүй өгөгдөлд оруулсан бол аль нь вэ?
 А. Бүтэц, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй
 В. Зорилгын хувьд харилцан адилгүй
 С. Албан тушаалын бүтэцийн хувьд харилцан адилгүй
 D. Чиглэлийн хувьд харилцан адилгүй
 E. Үүсгэн байгуулагчийн хувьд ялгаатай
27. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс үндэстэн дамнасан, үйл ажиллагааг явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид олон улсын байгууллагыг хэрхэн нэрлэдэг вэ?
 А. Улс бус оролцогч В. Их гүрэн С. Улс оролцогч D. Дунд улс E. Бага улс
28. Ёс суртахууны эрхэмлэн ямарч үед, аль ч нөхцөлд эмзэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулж байгаа зөөлөн хүчний бодлогын чиглэлийг тэмдэглэнэ үү?
 А. Улс төрийн дипломат ажиллагаа В. Эдийн засгийн дипломат ажиллагаа
 С. Соёлын дипломат ажиллагаа D. Цахим дипломат ажиллагаа
 E. Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа
29. Монгол улс бүрэн эрхт улсын хувьд олон улсын эрх зүйн хүрээнд 1961 оноос хойш өнөөг хүртэл ямар статустай байгаа вэ?
 А.Де-факто В.Социалист улс С.Тусгаар тогтносон улс D.Де-юре E.Ардчилсан
30. Монгол улстай өргөн хүрээтэй түншлэлийн харилцаатай улс аль нь вэ?
 А.ОХУ В.Канад, Австрали С.БНСУ, АНУ D.БНХАУ E.Япон, Энэтхэг

Хоёрдугаар хэсэг

2.1. Дараах өгөгдлийг зөв тохируулна уу.

1	Дээдийн доод анги	А	Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг
---	-------------------	---	--

2	Дээдийн дээд анги	B	Маш бага орлогтой, мэргэжилгүй, энгийн ажил эрхэлдэг
3	Ядуу ажилчин анги	C	Тун цөөн хувийг эзэлдэг. Байр суурь нь харьцангуй нээлттэй байдаг.
4	Доод анги	D	Тогтмол орлогын эх үүсвэргүй, бага боловсролтой эсвэл боловсролгүй, нийгмийн халамжаас хамааралтай амьдардаг

2.2. Зөв харгалзуулаарай.

1	Соёлын эрх чөлөө	A	Хүмүүс эх хэлээрээ ярьж, хувь чанараа хөгжүүлэх, нийгмийн баталгаагаар хангагдах, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрх
2	Соёлын адилсал	B	Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар
3	Соёлын орчин	C	Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, өөригөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухамсарлах
4	Соёлын дархлаа	D	Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин

2.3. Зөв харгалзуулна уу.

1	Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо	A	2 болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ
2	Тунхаглал	B	Хуульчлан дагаж мөрдөх албагүй, зөвлөмж , уриалгын шинжтэй
3	Конвенц, пакт	C	НҮБ-ийн хүний эрхийн байгууллагуудыг хоёр төрөлд хуваасан хүний эрхийг хамгаалах бодлого
4	Протокол	D	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэл, өөрчлөлт оруулсан баримт бичиг

2.4. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Гэм хор	A	Эрүүгийн хэрэгт заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл
2	Гэмт хэргийн бус зөрчил	B	Эрүүгийн хуулиас бусад хууль зөрчсөн гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдэл
3	Хор уршиг	C	Хохирлын улмаас бий болсон үр дагавар

4	Гэмт хэргийн зөрчил	D	Хохирол, хор үршгийг багтаасан ойлголт
---	---------------------	---	--

2.5. Ажилгүйдлийн хэлбэрийг зөв тохируулна уу?

1	Мөчлөгийн ажилгүйдэл	A	Шилжих хөдөлгөөнтэй холбогдон үүссэн ажилгүйдэл
2	Шилжилтийн ажилгүйдэл	B	Эдийн засгийн уналттай холбоотой үүссэн ажилгүйдэл
3	Бүтцийн ажилгүйдэл	C	Эдийн засаг дахь янз бүрийн салбаруудын эзлэх хувийн жин болон ажил, мэргэжлийн эрэлтийн өөрчлөлттэй холбоотой үүссэн ажилгүйдэл юм.
4	Улирлын ажилгүйдэл	D	Бат барилга дээр ажилладаг учраас өвөл ажил хийдэггүй.

2.6. Эдийн засгийн дараах ойлголтуудыг агуулгатай нь зөв холбоорой

1	Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орлогоор тооцох	A	Бүтээгдэхүүн үйлчилгээний экспортоос импортыг хассан дүн
2	Дотоодын нийт бүтээгдэхүүнийг зардлаар тооцох	B	Тухайн жилд нийт үйлдвэрлэлээс олсон орлого
3	Цэвэр экспорт	C	Эцсийн хэрэглээний бүх зардлын нийлбэр
4	ААН-н нэгжийн хөрөнгө оруулалтын зардал	D	Үйлдвэрлэлийн хэрэгсэл шинээр худалдан авсан зардал

2.7. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргийг зөв тохируулна уу?

1	Хүндэтгэх	A	Хүн бүр эрхээ эдлэхэд саад учруулахгүй байх, төрийн зүгээс ялгаварлан гадуурхахгүй байх.
2	Хангах	B	Хүн бүр эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, Эрх зүй, эдийн засгийн, нийгмийн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах.
3	Хамгаалах	C	Бусад хүн, байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, эрх зөрчигдвөл сэргээн эдлүүлэх.
4	Ахиц дэвшил гаргах	D	Хүний эрхийн талаар олсон ололт амжилтаа бататгаж, ямагт ахиц дэвшил гаргах.

A.1B 2C 3A 4D

B.1A 2B 3C 4D

C. 1C 2B 3A 4D

2.8. Сонгууль, сонгуулийн тогтолцоог зөв харгалзуулна уу? \5 оноо\

1	Сонгууль	A	Намын нэрээр санал хурааж, авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилах арга
---	----------	---	---

2	Мажоритари	B	Сонгууль явуулах, санал авах, дүн гаргах, суудал хуваарилах арга дүрэм, журмын цогцыг
3	Пропорциональ	C	Сонгогчид зөвхөн нэр дэвшсэн хүний л төлөө саналаа өгдөг ба өрсөлдөгчөөсөө хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцох арга
4	Сонгуулийн тогтолцоо	D	Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх түгээмэл арга хэрэгсэл.

2.9.3өв харгалзуулна уу.

a	Үндэстэн дамнасан корпорац	1	KFC, Toyota, Nissan
b	Хувь хүн	2	Олон улсын хэмжээнд мансууруулах бодис, санхүүгийн луйвар, террорист халдлага түгээмэл үйлддэг.
c	Гэмт хэргийн сүлжээ байгууллага	3	Билл Гейтс, Далай лам
d	Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4	CNN

2.10. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a	Ухаалаг хүчний бодлого	1	Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэхийг хэлнэ
b	Хатуу хүч	2	Улс өөрийн үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгсэлээ тэнцвэртэй хоршуулах чадвар
c	Зөөлөн хүч	3	Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа, болон санхүүгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал
d	Эдийн засгийн дипломат ажиллагаа	4	Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадвар

11 ДҮГЭЭР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

ХУГАЦАА-60 минут

Санамж: Өгөгдсөн даалгаврын зааврыг анхааралтай уншиж зөв хариултаа дугуйлаарай.

1-р хэсэг: Сонгох даалгавар зөвхөн нэг зөв хариултыг сонгоно.

2-р хэсэг: Харгалзуулах даалгавар тус бүр 1 оноотой.

“В” ВАРИАНТ

Нэгдүгээр хэсэг

- Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. Уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэм болон өөрчлөгдөхийг..... гэнэ.
А.Нийгмийнхувьсал В.Нийгмийншинэчлэл С.Нийгмийнхувьсгал D.Нийгмийнхяналт
E.Нийгмийнгажуудал
- Социализмын үеийн малчдын, ажилчдын сэхээтний, номуеклатурач (дарга) гэсэн ангийн бүтэцтэйгээр тодорхойлсон судлаач хэн бэ?
А. О. Мөнхбат В. Ц. Уртнасан С. Х. Гүндсамбуу D. Ц. Амартүвшин
- “Түн бага хувийг эзэлдэг ч нийгмийн баялгийн дийлэнх хэсгийг эзэмшдэг. Нийгмийн байр суурь нь үезалгамжилдаг”энэ шинжүүд нийгмийн ямар ангид хамаарах вэ?
А.Дээдийн доод В.Дээдийн дээд С.Дундын дээд D.Дундын дунд E.Ажилчин анги
- Шашны номлол, манугийн хуулиар хөдөлмөрийн хуваарийг тогтоосны дагуух, хувийн байр сууриа өөрчлөх болохаалттай давхраажилтын хэв маяг аль нь вэ?
А. Каст В. Боол С. Язгуур D. Анги
- Ард түмэн өөрийн соёлын хэм хэмжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү соёлын байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдлыг юу гэдэг вэ?
А. Соёлын даяаршил В. Соёлын аялал жуулчлал С. соёлын дархлаа D. Соёлын адилсал
- Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?
А. Бүсдын соёлыг хуулбарлан дүүриах В. Үр хүүхдээ сургах
C. мал маллах ухаан D. Язгуур уламжлалаа хадгалах
- Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой бүтээл туурвил, үйлчилгээ багтана. Үүнд хамаарах ойлголт аль нь вэ?
А.Соёлын цахим хэвлэл В. Соёлын аялал жуулчлал C.Соёлын даяаршил D.Соёлын орон зай
- Онолын хувьд аль нь буруу бодомж вэ? \2 оноо\
А. Соёл бол нийгмийн үзэгдэл мөн В. Нэг үндэстний соёл нь хэд хэдэн улсад байж болно.
C. Олон соёл нэг үндэстний дотор байж болно. D. Нэг тивд нэг л соёл байдаг.
- Төрийн өмчийн ЕБС-ийн багш нарыг зөөврийн компьютерээр хангасан нь зардлын аль төрөлд хамаарах вэ?
А.Гадаадын хэрэглэгчийн зардал В.Хувь хүний хэрэглээний зардал

С.Өрх гэрийн хэрэглээний зардал D.Аж ахуйн нэгжийн зардал E.Төрийн зардал

10. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын шимтгэлийг хэдэн сараас дээш хугацаагаар төлсөг тохиолдолд олгох вэ
A. 6 ба түүнээс дээш B. 3 ба түүнээс дээш C. 9 ба түүнээс дээш D. 2 ба түүнээс дээш
11. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрийн газар байгуулах эсвэл худалдан авч болдог үүнийг гэж нэрлэнэ.
A. Гадаадын шууд хөрөнгө оруулалт B. Хөрөнгө оруулалт C. Хөдөлмөрийн экспорт
D. Капиталын импорт
12. Аль нь ДНБ-ыг орлогоор тооцох өгөгдөл вэ ?
A.Өрх, гэрийн хэрэглээ B.Зээлийн хүү C.Төрийн худалдан авалтын зардал
D.ААН-ын зардал
13. Эдийн засгийн өсөлтийг урамшуулдаг ч инфляцийн эсрэг хүчин мөхөсддөг төрийн макро эдийн засгийн бодлого аль нь вэ?
A.Сангийн бодлого B.Мөнгө, зээлийн бодлого
C.Мөнгөний тэлэх бодлого D.Мөнгөний хумих бодлого
14. Монгол улсын засгийн газар 2013 оноос эхлэн Төрийн Үйлчилгээний Цахим /ТҮЦ/ машин ашиглан төрийнүйлчилгээг иргэдэд хурдан, шуурхай үзүүлж байна. “ТҮЦ” машинаас олгодог лавлагаанд аль нь хамаарахгүйвэ?
A. Дээд боловсролын дипломны лавлагаа B. Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа
C. Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа D. Гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа
15. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэсэн засаглал хуваах онолын үндэслэгчийг нэрлэнэ үү
A. М. Вебер B. Ж. Локк C. Ш. Монтесье D. К. Маркс
16. Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь аль байгууллагын чиг үүрэг вэ?
A.Засгийн газар B.УИХ C.Дээд шүүх D.Үндсэн хуулийн цэц E.Хүний эрхийн комисс
17. 2016 оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 45.69%-ийн санал авсан ч парламентийн суудлын 85.5%буюу 65-ыг авч байсан бол бусад нам эвсэлүүд нийт сонгогчдын 54.31%-ийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ. 2016 оны УИХ-н сонгууль нь сонгуулийн ямар тогтолцооны онцлогийгхаруулсан бэ?
A. Мажоритари тогтолцоо B. Пропорциональ тогтолцоо C. Хувь тэнцүүлэх тогтолцоо
D. Холимог тогтолцоо
18. 2017 оны Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль 6 сарын 26-нд зохион байгуулагдсан. Монгол Улсын түүхэнд анх удаа ерөнхийлөгчийн сонгуулийн хоёрдугаар шатны санал хураалтыг мөн оны 7 сарын 7-нд зохион байгуулж, түүний үр дүнд ерөнхийлөгчөөр сонгогдсон Халтмаагийн Баттулга 7 сарын 9-нд тангараг өргөжээ. Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль сонгуулийн тогтолцооны ямар хэлбэрээр явагддаг вэ?
A. Харьцангуй олонх B. Энгийн олонх C. Үнэмлэхүй олонх D. Хувь тэнцүүлэх
19. Хохирлын улмаас үүссэн үр дагаврыг гэнэ.
A. Хохирол B. Гэм хор C. Хор уршиг D. Гэмт хэрэг
20. Гомдол гаргаж буй иргэн, хуулийн этгээд, хариуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтан, гуравдагч этгээдийг захиргааны хэрэгт хэрхэн нэрлэдэг вэ?
A. Бусад хохирогч B. Хэргийн оролцогч C. Нэхэмжлэгч D. Хариуцагч
21. Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт:
A. Өргөдөл B. Хүсэлт C. Гомдол D. Санал
22.гэдэг нь үндсэн хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр өөринхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсвэл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ.

- A. Хүний эрхийн зөрчил В. Хүний эрхийг хамгаалах тогтолцоо С. Хууль тогтоох байгууллага
D. Гүйцэтгэх эрх мэдэл

23. Захиргааны хэргийн оролцогчид анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргах үүрэгтэй. Давж заалдах гомдол гарсан хэргийг давж заалдах шатны шүүх хүлээн авснаас хойш хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
A. 30, 30 В. 14, 3 С. 60, 14 D. 30, 60 E. 14, 60

24. Газар болон түүнээс салган ашиглах боломжгүй эд юмсыг юу гэж нэрлэдэг вэ?
A. Эдийн эрх В. Оюуны үнэт зүйл С. Хөдлөх хөрөнгө D. үл хөдлөх хөрөнгө
E. Өв залгамжлах эрх

25. Зөөлөн хүчний бодлогын төрлүүдийг дурдахдаа хамааралгүй өгөгдөл оруулсан бол аль нь вэ?
A. Бизнес инноваци В. Эдийн засаг С. Соёл D. Улс төрийн үнэт зүйл E. Гадаад бодлого

26. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид, олон улсын байгууллагууд олон улсын харилцааны ямар оролцогч болох вэ?
A. Улс оролцогч В. Улс бус оролцогч С. Субъект D. Объект

27. АСЕМ-ийн анхны дээд хэмжээний уулзалт хэзээ, хаана зохион байгуулагдсан бэ?

- A.1996 онд Германд В.2006 онд Финляндад С.2010 онд БНХАУ-д

D.1996 онд Тайландад E.1990 онд Японд

28. Улс өөрийн ашиг сонирхол, гадаад бодлогын зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрт байгаа улс төр, стратеги, эдийн засаг, соёл зэрэг бүх арга хэрэгслээ тэнцвэртэй хоршуулах чадварыг гэнэ.
A. Зөөлөн хүчний бодлого В. Ухаалаг хүчний бодлого С. Хатуу хүчний бодлого

D. Олон улсын бодлого

29. Европын холбоо, АПЕК, АСЕМ зэрэг хамтын ажиллагааны олон талт механизмууд идэвхтэй ажиллаж байгаа нь орчин үеийн олон улсын харилцааны аль хандлагыг илэрхийлэх вэ?

- A. Үндэстэн улсуудын харилцаа В. Даяаршлын бодлого С Түйлт харилцаа

D. Бүс нутгийн интеграцлал

30. Манай улс нь БНСУ –ын харилцаа хамтын ажиллагааг 2011 оны 8 сард иж бүрэн түншлэлийн харилцаанд дэвшүүлэн хөгжүүлэхээр хоёр тал тохиролцсон байна. Энэ нь ямар түвшний харилцааг хэлж байна вэ?

- A. Нийгмийн бүх салбарт хамтран ажиллах

В. Хоёр улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцаа

С. Зөвхөн газарзүйн ойлголт бус, Монголын ардчилал, эдийн засгийн өөрчлөлтийг дэмжигч ямар ч улстай хамтран ажиллах

D. Нийгмийн салбаруудын аль нэгийг голлон анхаарах, хөгжүүлэх

Хоёрдугаар хэсэг

2.1. Зөв харгалзуулаарай.

1	Нийгмийн ялгарал	A	. баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг.
2	Тэгш бус байдал	B	эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдал.
3	Нийгмийн давхраажилт	C	тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо юм.
4	Нийгмийн давхраа	D	нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ

2.2. Соёлын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? \5 оноо\

A 2	Бэлгэ тэмдэг	1	Нийгмийн зүгээс хайрлан хүндлэгдэж, хамгаалагдсан үйлдлийн томоохон загвар
B 4	Үнэлэмж	2	Нийгмийн гишүүд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх үйлдэл, объект
C 3	Хэм хэмжээ	3	Ямар ч үед байнга дагаж мөрдөж байх үйл, төрх байдлын ерөнхий дүрэм
D 1	Зан үйл	4	Юуг сайн, хүсүүштэй хийгээд зохистой, юуг муу, хүсүүшгүй бөгөөд зохисгүй гэж үздэг талаарх хамтын ойлголтууд

2.3. Зөв харгалзуулаарай.

1D	Дотоодын нийт бүтээгдэхүүн	A	Өнөөгийн үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн
2B	Үндэсний нийт бүтээгдэхүүн	B	Дотоодын болон гадаадад байгаа тухайн улсын иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
3C	Бодит Дотоодын нийт бүтээгдэхүүн	C	Тогтмол үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн
4A	Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн	D	Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн дүн

2.4. Зөв харгалзуулаарай

1D	Өрх гэрийн хэрэглээний зардал	A	ААН, байгууллага өөрийн үйл ажиллагааг явуулхын тулд эдийн засгийн тодорхой нөөцүүдийг худалдан авахад төлж буй мөнгөн төлбөр
2A	ААН-н хөрөнгө оруулалтын зардал	B	Цагдаа , цэрэг, сурагч, эмч , багш болон төрийн албан хаагчдад зориулсан бүтээгдэхүүн , үйлчилгээ худалдан авах, сургууль, эмнэлэг, зам, гүүр зэргийг барихад гаргасан зардал
3B	Төрийн зардал	C	Үүнийг экспорт , импортын зөрүү буюу цэвэр экспортын хэмжээгээр тодорхойлно
4C	Гадаадын хэрэглэгчдийн зардал	D	Өрх гэрүүд хэрэглээндээ зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардал

2.5. Зөв харгалзуулна уу?

5 A	Сонгууль	1	Тухайн сонгуулийн тойргоос парламентад суух суудлын эрх
6 B	Сонгуулийн хувь тогтолцоо	2	Хоёр ба түүнээс дээш нэр дэвшигч эсвэл улс төрийн намаас сонголт хийх иргэний эрх
4 C	Сонгуулийн мандат	3	Сонгогчид дэмжиж буй намынхаа төлөө саналаа гаргах бөгөөд намуудын авсан саналын дагуу парламентын суудал хуваарилах

3	Сонгох эрх	4	Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх
---	------------	---	--

2.6. Зөв харгалзуулна уу?

1	Ш. Монтескье	A	Аливаа төрд гурван төрлийн эрх мэдэл оршдог. Хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл гэсэн байдаг
2	Хууль тогтоох эрх мэдэл	B	Шүүх
3	Гүйцэтгэх эрх мэдэл	C	УИХ
4	шүүх	D	Засгийн газар

2.7. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1. Хариуцлага d	a. Гэм буруутай төлбөр төлөгч тал
2. Гэм буруутан a	b. Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол
3. Гэм хор b	c. Гэмт үйлдлийн үр дүнд бий болсон алдагдал гэмтэл төлбөр
4. Хохирол	d. Гэм буруутай этгээд буруутай үйлдлийнхээ төлөө бусдын өмнө хүлээх үүрэг

2.8. Зөв тохируулаарай

1	Тунхаглал	A	Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичиг юм.
2	Конвенц	B	Хоёр болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ юм.
3	Протокол	C	Хуульчлан дагаж мөрдөх албагүй, зөвлөмж, уриалгын шинжтэй баримт бичиг юм.
4	Пакт	D	2 болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ

2.9. Зөв тохируулаарай

1	НҮБ	A	1945 онд АНУ-ын Сан Франциско хотноо анх 51 улсын оролцоотойгоор байгуулагдсан
2	Олон тулгуурт байх	B	Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэнд чиглэнэ
3	Прамастик байх	C	Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
4	Тэнцвэртэй байх	D	Монгол улсын үндэсний эрх ашиг, аюулгүй байдлыг сахин хамгаалах, үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.

2.10. Олон улсын харилцааны улс оролцогчдын талаарх ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Бага улс	A	Өөрийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш, холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг
---	----------	---	--

2	Де-юре	B	Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бус нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд байдаг.
3	Их гүрэн	C	Тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр буюу "хууль ёсны" гэсэн утгатай.
4	Дунд улс	D	Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг.